- Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 340,486.6 мянган төгрөгөөр өссөн. Үүнд: Үндсэн санхүүжилтийн төрийн сангийн дансны үлдэгдэл 147,279.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 193,206.7 мянган үүнээс ЭМЯ-ны эрүүл мэндийн ажиллагсад олгосон мөнгөн дэмжлэгийн үлдэгдэл 19,500.0 мянган төгрөг олгогдоогүй, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс резидент эмч нарын цалин хөлсний үлдэгдэл 2,349.1 мянган төгрөг, эрүүл мэндийн дэмжих сангийн төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн үлдэгдэл 57,558.7 мянган төгрөг, НҮБ-ын Хүүхдийн сангийн төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн үлдэгдэл 113,769.0 мянган төгрөг байгаагаас тус тус шалтгаалсан.
- Дансны авлага 953.669.4 мянган төгрөг буюу Эрүүл мэндийн даатгалын сангаас авах төлбөртэй тусламж үйлчилгээний авлагатай холбоотойгоор өмнөх оноос 848,614.4 төгрөгөөр нэмэгдсэн.
- Урьдчилж гарсан тооцоо 22,563.3 мянган төгрөг буюу өмнөх оноос 32,595.6 мянган төгрөгөөр буурсан нь мэдээлэл сурталчилгааны ажлууд хийгдэж дууссантай холбоотой, бараа материалын үлдэгдэл 728,004.2 мянган төгрөг өмнөх оноос 71,603.7 мянган төгрөгөөр буурсан нь эмийн нөөц их байсан.
- Үндсэн хөрөнгө 17,493,643.7 мянган төгрөг буюу өмнөх оноос 474,393.7 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө тайлант онд 840,939.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж 294,414.8 мянган төгрөгөөр хасагдсан. Үүнээс худалдаж авсан 152,266.0 мянган төгрөг, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 619,304.7 мянган төгрөг, хандив тусламжаар 66,968.5 мянган төгрөг, бараа материалаас шилжүүлж авсан 1,900.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн устгалаас 500.0 мянган төгрөгийн хөрөнгө орлого авсан, худалдсан 62,250.0 мянган төгрөг, акталж устгасан 231,606.8 мянган төгрөг, бараа материал дансанд шилжүүлсэн 558.0 мянган төгрөг, тайлант онд байгуулсан элэгдэл 1,295,107.3 мянган төгрөгөөс тус тус шалтгаалж буурсан.
- Өглөгийн оны эцсийн үлдэгдэл 264,424.2 мянган төгрөг үүнээс байгууллагад төлөх өглөг 216,758.0 мянган төгрөг, дэмжих сангийн судалгааны ажлын санхүүжилт 47,666.2 мянган төгрөг урьдчилж орсонтой холбоотой өглөг үүссэн байна.
- Хуримтлагдсан үр дүн 1,904,639.2 мянган төгрөг өмнөх оны үр дүнгээс 346,083.8 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>Үйл ажиллагааны орлогын дүн</b>	<b>14,669,461.9</b>	<b>14,928,742.3</b>	<b>259,280.4</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	551,615.1	559,463.7	7,848.6
Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	1,973,608.7	686,773.3	(1,286,835.4)
Үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал	113,189.9	359,206.7	246,016.8
Улсын төвлөрсөн төсвөөс	11,630,855.8	-	(11,630,855.8)
Нэмэлт санхүүжилтийн орлого	400,192.4	1,300,055.0	899,862.6
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	-	12,023,243.6	12,023,243.6
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>13,351,786.0</b>	<b>14,562,990.9</b>	<b>1,211,204.9</b>
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,659,608.3	8,056,692.3	397,084.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл	994,657.9	1,104,948.1	110,290.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	627,033.0	547,517.2	(79,515.8)
Хангамж, бараа материалын зардал	182,839.4	240,872.5	58,033.1
Нормативт зардал	1,963,556.8	2,253,944.2	290,387.4
Эд хогшил, урсгал засварын зардал	110,317.9	170,698.0	60,380.1
Томилолт, зочны зардал	2,927.1	55,416.0	52,488.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	212,276.0	187,418.4	(24,857.6)
Бараа үйлчилгээний бусад зардал	1,350,346.4	1,307,279.8	(43,066.6)
Бусад урсгал шилжүүлэг	248,223.2	638,204.4	389,981.2
<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>1,317,675.9</b>	<b>365,751.4</b>	<b>(951,924.5)</b>
Үйл ажиллагааны бус үр дүн	686,176.5	(19,667.6)	(705,844.1)
<b>Нийт үр дүн</b>	<b>2,003,852.4</b>	<b>346,083.8</b>	<b>(1,657,768.6)</b>

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлого 14,928,742.3 мянган төгрөг өмнөх оноос 259,280.4 мянган төгрөг буюу 1.8 хувиар өссөн нь үндсэн үйл ажиллагааны орлого 7,848.6 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан бараа материал 246,016.8 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 899,862.6 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 12,023,243.6 мянган төгрөгөөр өсөж, үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн орлого 1,286,835.4 мянган төгрөг, улсын төсвийн санхүүжилт 11,630,855.8 мянган төгрөгөөр буурсан.

Үйл ажиллагааны зардал 14,562,990.9 мянган төгрөг өмнөх оноос 1,211,204.9 мянган төгрөг буюу 9.1 хувь өссөн нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 79,515.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 24,857.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 43,066.6 мянган төгрөг буурч, цалин, хөлс нэмэгдэл урамшуулал, 397,084.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 110,290.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 58,033.1 мянган төгрөг, нормативт зардал 290,387.4 мянган төгрөг эд хогшил урсгал засварын зардал 60,380.1 мянган төгрөг, томилолт зочны зардал 52,488.9 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 389,981.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Энэ нь эрүүл мэндийн даатгалын сангаас нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжиж гүйцэтгэлд суурилсан санхүүжилт авч үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагын ТУЗ байгуулаагүйгээс эрх үүргээ хэрэгжүүлж хяналт тавьж ажиллаагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 13,026,316.2 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч хүргүүлсэн төсвийн төслийг 1,153,856.4 мянган төгрөгөөр бууруулан 11,872,459.8 мянган төгрөгөөр баталсан байна. Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг Эрүүл мэндийн яамнаас шууд олгодог болсон тул урсгал зардлаас 193,788.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Коронавируст халдвар авсан иргэнийг эмчлэх арга хэмжээнд зарцуулсан эмнэлгийн нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл, цалин хөлсний зардал, эрүүл мэндийн даатгалаас санхүүжих Ковидын тусламж үйлчилгээний санхүүжилтийг үндэслэн батлагдсан төсвийг 108,709.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож, 11,981,168.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 11,981,168.8 мянган төгрөгийг баталсан байна.

Төсвийн орлогын 11,421,168.8 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээр, 560,000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүрдүүлэхээр төлөвлөн ажилласан ба гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 11,072,359.7 мянган төгрөг буюу 96.9 хувь, үндсэн үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 560,283.7 мянган төгрөг 100.1 хувьтай байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 11,485,363.5 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын зардлыг 143,758.2 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 30,099.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 83,912.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 19,206.5 мянган төгрөг, нормативт зардлыг 211,061.6 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 5,762.5 мянган төгрөг, томилолтын зардлыг 654.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бусад ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 673.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлыг 592.4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж шагнал, урамшууллын зардлыг 83.3 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71602	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	11,981,168.8	11,485,363.5	495,805.3	95.9
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	11,981,168.8	11,485,363.5	495,805.3	95.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3. Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс авсан хандив, тусламж 334,710.5 мянган, дээд шатны төсвийн захирагчаас 1,114,960.9 мянган, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3,104.7 мянган төгрөг, нийт 1,452,776.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

2021 онд нийт 18 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн ба шинээр Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт өөрчлөлт орж, 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөж, нийт 277,267.4 мянган төгрөгийн резидент эмч нарын цалинг нэмэлт санхүүжилтийн дансаар олгосон байна. Мөн эмнэлгийн ажилтнуудад олгох нэг удаагийн мөнгөн дэмжлэгт нийт 609,200.0 мянган төгрөг олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5.1-д харуулав

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь 2021 оныг хүн амд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг илүү боловсронгуй болгох зорилгоор “Цахим технологийн шинэчлэлтийн жил” болгон зарлан нийт 131 ажил төлөвлөж, 129 ажлын биелэлтийг ханган 98.4 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 1 арга хэмжээний хэрэгжилт 100 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 95.9 хувийн биелэлттэй, 4.1 хувь буюу 495,805.3 мянган төгрөг байна.

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Код	Нэр				
1	80101	Ковид-19 цар тахлын үед нийгэм сэтгэл зүйн тусамж үзүүлэх сургалт, видео бэлтгэх	5	4	1	85.7
2	80101	Хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчдэд сэтгэл зүйн тусламж үзүүлэх арга техникийн сургалт, гарын авлага бэлтгэх	5	5		100
3	80101	Хүүхэд өсвөр үеийнхний дунд тохиолддог сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг илэрхийлэх тусламж үзүүлэх арга техникийн гарын авлага бэлтгэх	5	5		100
4	80101	Архи тамхи донтолтын эсрэг сургалт	2	2		100
5	80101	Жирэмсэн эхийн сэтгэл гутрал тусламж үйлчилгээний сургалт	2	1	1	50
6	80101	Аутизмын ооншилгоо эмчилгээний арга техник нэвтрүүлэх	2	1	1	50
<b>Нийт</b>			<b>21</b>	<b>18</b>	<b>2</b>	<b>85.7</b>

### 3.8 Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулиудад өөрчлөлт орж Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эрүүл мэндийн даатгалаар санхүүжиж эхэлсэн.

ЭМДҮЗ-ийн 03 дугаар тогтоол 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр батлагдаж 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн тул ЭМДЕГ нь 2021 оны 1, 2 дугаар сарын гүйцэтгэлийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дүнгээр санхүүжүүлсэн.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь төлөөлөн удирдах зөвлөл байгуулаагүй нь санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал болж байна.

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/565 дугаар тушаалын 2 дугаар заалтад Төрийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийг төлөөллийг нэр дэвшүүлэн сонгох хурлыг зохион байгуулах, сонгон шалгаруулах хороог байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргад даалгасан, мөн тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан журмын 1.2.1-т сонгон шалгаруулалтыг зохион байгуулах хороог Эрүүл мэндийн яам болон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэд байгуулна гэж заасан, Эрүүл мэндийн тухай хууль 17 дугаар зүйлийн 17.1-т "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн өмчтэй холбогдох харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар, удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хүний нөөцтэй холбогдох харилцааг энэ хууль болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар зохицуулна", 17.10, 17.11, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16.6.3, 16.6.4 заалтуудыг тус тус зөрчиж Төлөөлөн удирдах зөвлөл байгуулаагүйгээс төсвийг бүлэг хооронд шилжүүлэн зориулалт бусаар зарцуулах, түүнд тавих хяналтыг сулруулж байгааг цаашид анхаарах шаардлагатай.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зорицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь 2021 онд нийт 14,957,656.5 мянган төгрөгийн 119 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас, 4 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах. Зөвлөмж өгөв.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эрүүл мэндийн яам төлөөлөн удирдах зөвлөлийг сонгон шалгаруулах комисс томилох ажлыг хэрэгжүүлээгүйгээс тус эмнэлэг нь төлөөлөн удирдах зөвлөл байгуулж ажиллаагүй, эмнэлгийн ерөнхий захирал нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд ажиллах байтал төлөөлөн удирдах зөвлөлийн эрх үүргийг эмнэлгийн ерөнхий захирал хэрэгжүүлж хууль эрх зүйн актыг зөрчиж байна.

**Шийдвэрлэсэн нь:** Эрүүл мэндийн тухай хуулийн 17.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.10-т заасан суман дахь нэгдсэн эмнэлгээс бусад нэгдсэн эмнэлгийн удирдлагыг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл, түүнээс томилсон гүйцэтгэх удирдлага хэрэгжүүлнэ.” гэсэн заалтын дагуу төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулан ажиллаагүй байсан зөрчлийг арилгах. Зөвлөмж .өгөв

### 3.10 ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Завсрын аудитаар нийт 350,208.9 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илрүүлснээс 349,119.8 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1,089.1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн цар тахлын үед эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах тухай ерөнхий захирлын 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өрийн А/07 дугаар тушаалын дагуу 12,317.2 мянган төгрөгийн халдвар хамгааллын хувцас хэрэгслийг зардлаар тайлагнаж, эмийн зардал өссөн алдаа зөрчилд, эмнэлгийн төлбөрт үйлчилгээний орлогын Э-хэйлт программаар бичигдсэн мэдээллийг кассын орлоготой тулган шалгаж 365.0 мянган төгрөгийн зөрүүтэй алдаа зөрчилд өгсөн 2 зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байна.

*Хүснэгт-4* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	12,682.2	2	12,682.2			
Нийт дүн	2	12,682.2	2	12,682.2			-

### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн гүйцэтгэл, Э-хэйлт программ дахь төлбөрт үйлчилгээний гүйцэтгэлийг дараагийн аудитаар авч үзнэ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 483,599.5 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илэрснээс 349,119.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 1,229.1 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 628.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 132,621.9 мянган төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Залруулгадаагүй 134,479.7 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс 11,150.2 мянган төгрөгөөр бага тул зөрчилгүй санал дүгнэлт өгсөн.

##### 4.1 ЗАЛРУУЛСАН АЛДАА

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

Үүнд:

- Бэлтгэн нийлүүлэгчээс е-баримтаар баталгаажсан төлбөрийн баримтаар гүйлгээ хийгээгүйгээс 264,533.5 мянган төгрөгийн баримт анхан шатны баримтын шаардлага хангаагүй;
- Клиник, тасгуудын яаралтай эмийн нөөцийн захиалгыг эмийн эргэлтийн сангаас дотоод шилжүүлэг хийлгүй захиалгын хуудсаар 1,846.8 мянган төгрөгийн эм боох материалыг зарлага болгож тайлагнасан;
- ХХОАТ-ын тайланд гэрээгээр ажил гүйцэтгүүлсэн 17 иргэний ажлын хөлс 82,739.5 мянган төгрөгийг тайлагнаагүй байсныг тус тус залруулсан.

##### 4.2 АЛБАН ШААРДЛАГА

1. Сэтгэц эрүүл мэндийн үндэсний төвөөс иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын нэхэмжилсэн дүн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон төлбөрт үйлчилгээний дүнгээс 1,234,647.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь яаралтай тусламжийн эрэмбэ буурсан, амбулаторийн нэгээс дээш кабинетаар үзүүлж дараагийн төлбөрийн хувь буурсан, эрүүл мэндийн байгууллагаас хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг давхардуулан авсан, 14 хоногийн дотор амбулаторийн үйлчилгээ авснаас төлбөрийн хувь буурсан, эмчийн онош зөрсөн, хэвтэн эмчлүүлсэн нэхэмжлэлийн огноо зөрүүтэй, программыг холбогдох журамтай уялдуулж хийгээгүйгээс шалтгаалан хасагдсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэл хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Э-хэйлт программд зөв мэдээллийг оруулах, иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг даатгалын сангаас санхүүжүүлэх журмын дагуу иргэдээс төлбөр тооцоог аваагүй, нэхэмжлээгүй, давхардуулсан алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх. Албан шаардлага хүргүүлэх.

2. Ковидын тасагт 8 сард хэвтэн эмчлүүлсэн 65 эмчлүүлэгчийн эмийн олголтыг өвчний түүхтэй тулган шалгахад Э-хэйлт программд эмчлүүлэгчийг эмнэлгээс гарсны дараа эмчилгээний заалтыг хааж өгөөгүйгээс хэрэглэсэн эм нь эмийн сангийн олголтоос 628.7 мянган төгрөгөөр илүү байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 20.4-т "Нягтлан бодох бүртгэл



хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", гэсэн заалтыг хэрэгжүүлж, хяналт тавьж ажиллаагүй байгаа нь тохиолдсон байх, хэмжилт, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэл хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Э-хэйлт программыг сайжруулж, эм олголтод хяналтыг бүрэн тавих. Албан шаардлага хүргүүлэх.

#### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Авлагын данстай холбоотой асуудал**

###### **Илрүүлэлт:**

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлагын дансны эцсийн үлдэгдэл нь тооцоо нийлсэн актаас 132,621.9 мянган төгрөгөөр зөрүүтэй, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 67/А/268 дугаар тушаалаар баталсан журам, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 05/А/12 дугаар тушаалын дагуу хийсэн Ковидын ПГУ, түргэвчилсэн, тандалтын шинжилгээ нь баримтаар нотлогдон нэхэмжилсэн боловч Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг олгоогүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого", 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

###### **Өгсөн зөвлөмж:**

Анхан шатны баримтыг Tandalt.gov.mn цахим программтай тулган шалгалт хийж, авлагыг баталгаажуулах.

##### **2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

###### **Илрүүлэлт:**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглалтад байгаа, дахин үнэлгээ хийгээгүй үндсэн хөрөнгө данс бүртгэлтэй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

###### **Өгсөн зөвлөмж:**

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтад байгаа үндсэн хөрөнгийг дахин үнэлэх үнийг шинэчлэн тогтоох, цаашид ашиглах боломжгүй гэж мэргэжлийн хяналтын байгууллагаас дүгнэлт гарсан хөрөнгийг мэргэжлийн хяналтын дүгнэлтийг биелүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/ мянган төгрөг/

Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаарлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
						Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	оо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар															
1	СЭМҮТ	АХГ-2022/367/НА-СТА-ТШЗ	Бэлтгэн нийлүүлэгчдээс Е-баримтаар баталгаажсан төлбөрийн баримт бичүүлж аваагүйгээс анхан шатны баримтын шаардлага хангаагүй 264,533,467 төгрөгийн ажил гүйлгээ хийгдсэн байна.	Анхан шатны баримт болох ебаримт-аар үндэслэн төлбөр, тооцоог гүйцэтгэж байх	1	264,533.5	1	264,533.5							
2	СЭМҮТ	АХГ-2022/367/НА-СТА-ТШЗ	Төлбөрт үйлчилгээний орлогыг амбулаторийн үзлэгийн бүртгэлтэй тулган шалгахад Пос машинаар уншуулсан төлбөрөөс буцсан 140,000 төгрөгийг касст орлого аваагүй дутагдал гарсан байна	Пос машинаар уншигдаагүй буцсан орлогыг хариуцсан ажилтнаар төлүүлнэ.	1	140.0			1	140.0					
3	СЭМҮТ	АХГ-2022/367/НА-СТА-ТШЗ	Клиник, тасгуудын яаралтай эмийн нөөцийн захиалгыг эмийн эргэлтийн сангаас олгохдоо дотоод шилжүүлэг хийлгүй 1,846,822 төгрөгийн эм, боох материалыг зарлага болгосон байна.	Тасгуудын яарартай эмийн нөөцийг орлого авах	1	1,846.8	1	1,846.8							



			тандалтын шинжилгээ нь баримтаар нотлогдон нэхэмжилсэн боловч Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг олгоогүй байна.														
7	СЭМҮТ	АХГ-2022/367/НА-СТА-ТШЗ	СЭМҮТ-өөс иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын нэхэмжилсэн дүн нь эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон төлбөрт үйлчилгээний дүнгээс 1,234,647,551 төгрөгөөр зөрүүтэй байгаа нь яаралтай тусламжийн эрэмбэ буурсан, амбулаторийн нэгээс дээш кабинетаар үзүүлж дараагийн төлбөрийн хувь буурсан, эрүүл мэндийн байгууллагаас хэвтүүлэн эмчлэх үйлчилгээг давхардуулан авсан, 14 хоногийн дотор амбулаторийн үйлчилгээ авнаас төлбөрийн хувь буурсан, эмчийн онош зөрүү, хэвтэн эмчлүүлсэн нэхэмжлэлийн огноо зөрүүтэй, программыг холбогдох журамтай уялдуулж хийгээгүйгээс шалтгаалан хасагдсан байна.	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 03 дугаар тогтоол, “Хяналтын журам батлах тухай” 05 дугаар тогтоолуудаар батлагдсан журмуудын дагуу цахим эмнэлгийн тусламж үйлчилгээний Э-хэйлт програмд зөв мэдээллийг оруулах, эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудыг цахим системд сургах, иргэний мэдээллийг шалгаж, давтан хэвтүүлэх зөрчил гаргахгүй байх	1	-					1	-					

8	СЭМҮТ	АХГ-2022/367/НА-СТА-ТШЗ	СЭМҮТ-ийн ерөнхий захирлын А/01 тушаалын Хавсралт 6-р тогтоосон үндсэн цалингаас 4 хүний 1,089,094 төгрөгийн цалинг илүү олгосон байна.	СЭМҮТ-ын нэр бүхий 4 хүний илүү олгосон цалинг суутгах	1	1,089.1			1	1,089.1							
9	СЭМҮТ	АХГ-2022/367/НА-СТА-ТШЗ	ХХОАТ-ын тайланд гэрээгээр гүйцэтгүүлсэн 17 иргэнтэй орчуулгын ажлын хөлс 82,739,500 төгрөгийг тайлагнаагүй Е-баримт шивж өгсөн байна.	ХХОАТ-ын тайланг нөхөн гаргах	1	82,739.5	1	82,739.5									
Дүн					9	483,599.5	3	349,119.8	2	1,229.1	2	628.7	0	0	2	132,621.9	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																	
1	СЭМҮТ	АХГ-2022/367/НА-СТА-ТШЗ	1. Төлөөлөн удирдах зөвлөл байгуулж ажиллаагүй байна.  2. Эмнэлгийн ерөнхий захирал нь төлөөлөн удирдах зөвлөл байгуулан түүнээс олгосон эрх хэмжээний хүрээнд ажиллах байтал төлөөлөн удирдах зөвлөлийн эрх үүргийг эмнэлгийн ерөнхий захирал хэрэгжүүлж хууль эрх зүйн актыг зөрчиж байна.	Төлөөлөн удирдах зөвлөлд ажиллах олон нийтийн төлөөллийг нэр дэвшүүлэн сонгох хурлыг зохион байгуулах, сонгон шалгаруулах хороог байгуулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргад даалгасан боловч хэрэгжээгүйгээс СЭМҮТ нь 2021 оны төсөв, орон тоо батлагдаагүй байна.	1	-									1	-	

2	СЭМҮТ	АХГ-2022/367/НА-СТА-ТШЗ	Шилэн дансанд хугацаа хоцруулсан 4 мэдээлэл байна	Шилэн дансны цахим систем мэдээллийг хуулийн дагуу тайлагнах	1	-									1	-
Дүн					2	0	0	0	0	0	1	0	0	0	2	0
Нийт дүн					11	483,599.5	3	349,119.8	2	1,229.1	3	628.7	0	0	4	132,621.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 43/А0150054  
АХГ- 2022/307/МА-СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирлын 2021 оны А/01 тушаалын хавсралтаар тогтоосон үндсэн цалингаас 4 нэр бүхий хүний 1,089,094.0 төгрөгийн цалинг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 1,089,094.0 төгрөгийн цалинг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ерөнхий захирал Л.Насанцэнгэл, ахлах нягтлан бодогч Ц.Хэрлэнцэцэг нарт даалгав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ АУДИТОР

Д.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
М.СЭВЖИДМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25 № 49/А0150054

Улаанбаатар хот

АХГ-2022/1367/НАБ-СТА-ТЦУ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлбөрт үйлчилгээний орлого 140,000.0 төгрөгийг дансанд тушаагаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үйлчилгээний орлого 140,000.0 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ерөнхий захирал Л.Насанцэнгэл, ахлах нягтлан бодогч Ц.Хэрлэнцэцэг нарт даалгав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Ф.ГҮНЖИДМАА

М.СЭВЖИДМАА







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 255/А 0150054  
АХГ-2022/367/НБ - СТА - ТУС

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлын нэхэмжилсэн дүн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас олгосон санхүүжилтийн дүнгээс 1,234,647,551.00 төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам"-ын 1.1 заалтыг "1.1. Эрүүл мэндийн даатгал (ЭМД)-ын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.3, 9.1.5, 9.1.10 9.1.11 заасан эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тшаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Э-хэйлт цахим эрүүл мэндийн программд зөв мэдээлэл оруулах, иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардлыг даатгалын сангаас санхүүжүүлэх журмын дагуу иргэдээс төлбөр тооцоог аваагүй, нэхэмжлээгүй давхардуулсан алдаа зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ерөнхий захирал Л.Насанцэнгэл, ахлах нягтлан бодогч Ц.Хэрлэнцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Г.ГҮНЖИДМАА  
М.СЭВЖИДМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 254/А.0150054  
АХГ-2022/367/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ковидын тасагт 8 сард хэвтэн эмчлүүлсэн 65 эмчлүүлэгчийн эмийн олголтыг өвчний түүхтэй тулган шалгахад программд эмчлүүлэгчийг эмнэлгээс гарсны дараа эмчилгээний заалтыг хааж өгөөгүйгээс хэрэглэсэн эм нь эмийн сангийн олголтоос 628,673.55 төгрөгөөр илүү байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 20 дугаар зүйлийн 20.4 "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Э-хэйлт программыг сайжруулж, эм олголтод хяналтыг бүрэн тавих, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг ерөнхий захирал П.Насанцэнгэл, ахлах нягтлан бодогч Ц.Хэрлэнцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
СИ ЭС АЙ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
П.ГҮНЖИДМАА  
М.СЭВЖИДМАА



# ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines for writing the conclusion.

